

БХИС-ийн захирлын 2013 оны 04 дүгээр
сарын 29-ний өдрийн А/261 дүгээр
тушаалын хавсралт

**“СУРГАЛТАД ШИЛДЭГ АРГА ЗҮЙ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН
БАГШИЙГ 2 САР ТУТАМ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”**

НЭГ. Нийтлэг үндэслэл.

Зорилго: БШУЯ-аас 2013 оныг “Багш нарын сургалтын арга зүй, технологийг шинэчлэх жил” болгон зарласантай холбогдуулан БХИС-ийн багшлах бүрэлдэхүүний сургалтын ажилдаа нэвтрүүлж буй дэвшилтэт технологи, заах арга зүй, ур чадварыг бодитой үнэлж, урамшуулах, нийтийн хүртээл болгон, багшийн хөгжлийг дэмжих, “БХИС-ийн сургалтын шилдэг арга зүй, технологийн сан”-тай болж бүртгэн, албажуулахад чиглэгдэнэ.

Хамрах хүрээ: БХИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн тэнхим, нийтлэг үйлчилгээний тэнхимийн /төв/-ийн нийт багш нар хамрагдана.

Шалгаруулах хугацаа: Шилдэг арга зүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн багшийг тэгш тоотой сар бүрийн 15-30-ны дотор шалгаруулах ба, энэхүү дүнг тухайн жилийн оны тэргүүний багш шалгаруулах уралдаан дүгнэхэд онцгойлон харгалзаж үзнэ.

Хоёр. Шалгаруулах ажлын зохион байгуулалт.

2.1. Тухайн сард сургалтанд шилдэг арга зүй, дэвшилтэт технологи нэвтрүүлж хэрэгжүүлсэн, тэргүүний, шилдэг заах арга зүйч багшийг сар бүр гурван үе шаттайгаар шалгаруулна.

А. Нэгдүгээр шатны шалгаруулалтыг харъяа тэнхим /төв/-үүд зохион байгуулж, шалгарсан 1 багшийн нэрийг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албадад тухайн сарын 15-ны дотор ирүүлнэ.

Б. Бүрэлдэхүүн сургуулийн удирдлага, сургалтын албад тэнхим тус бүрээс шалгарч, нэр дэвшигдсэн багш нарын хичээлд суун, багшийн ур чадварыг энэхүү үзүүлэлтийн дагуу дүгнэн байр эзлүүлж, нийлбэр дүн болон шалгарсан 1 багшийн нэр, ажлын гол үзүүлэлтийг нотломжийн хамт СБЗА-нд тэгш тоотой сарын 20-ны дотор албан бичгээр ирүүлнэ.

В. Бүрэлдэхүүн сургууль, нийтлэг үйлчилгээний тэнхим /төв/-ээс эхний байранд шалгарсан багш нарын хичээлд СБЗА, ЭШДМСА, ИӨҮА-ны мэргэжилтнүүд сууж,

шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч, дүнг БХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

Гурав. Бүртгэх, сан бүрдүүлэх, сурталчлах.

СБЗА, бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран тухайн сард шалгарсан багш нарын сургалтын шилдэг арга зүй, технологийг “БХИС-ийн сургалтын шилдэг арга зүй, дэвшилтэт технологийн сан”-д оруулж, бусдад сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, улмаар БШУЯ-нд бүртгүүлэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Шагнал урамшуулал.

БХИС-ийн хэмжээнд тухайн сард тэргүүн байр эзэлсэн 1 багшийн сарын үндсэн цалинг 1 сар 30% хүртэл, хоёрдугаар байр эзэлсэн 1 багшийн сарын үндсэн цалинг 1 сар 20% хүртэл тус тус нэмэгдүүлэн шагнаж урамшуулна.

СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА

“СУРГАЛТАД ШИЛДЭГ АРГА ЗҮЙ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАГШ”-ИЙГ 2 САР ТУТАМ ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д.д	Шалгуур үзүүлэлтүүд		Болзолт оноо	Авсан оноо
Нэг. Сургалтанд шинэлэг арга зүй, шинэ технологи хэрэгжүүлсэн талаар:				
1.	Заах арга зүй, технологийн	Заах арга зүйн шинэлэг хэлбэрийг хэрэглэсэн байдал	5	
2.	шинэлэг хэлбэр	Хичээл, сургалтандаа шинэ технологи нэвтрүүлсэн байдал	5	
Оноо			10	
Хоёр. Хичээлийн бэлтгэл хангаж, сургалтын орчин бүрдүүлсэн талаар:				
1.	Сэтгэл зүйн орчин	Суралцагсдыг сэдэлжүүлж, идэвхижүүлэх ур чадвар	4	
		Суралцагсдын тухайн хичээлд өгөх сэтгэл ханамж	4	
2.	Материаллаг орчин	Хичээлийн стандарт хөтөлбөр, цаг сэдвийн болон хичээл удирдах төлөвлөгөө, хичээлийн бэлтгэл	5	
		Ангийн болон хувийн журнал хөтлөлт	4	

3.	Үйлийн орчин	Анги танхим, лаборатори, дадлагын байр, самбар, шохой, техник хэрэгсэлийн ашиглалт	4	
		Багшийн дүр төрх /имиж/, биеийн хэл, хувцаслалт	4	
Оноо			25	
Гурав. Багшийн сургах арга зүйн ур чадварын талаар:				
1.	Багшийн хичээл заах ур чадвар, сурган хүмүүжүүлэх, мэдлэг бүтээх арга, ажиллагаа	Хичээлийн сэдэв, агуулгаа бусад хичээлтэй уялдуулан холбох ур чадвар	4	
		Хичээлийн практик ач холбогдол, хэрэгцээг суралцагсдад тайлбарлан ойлгуулах чадвар	4	
		Судалж буй сэдвийн хүрээнд багтах юмс үзэгдлийн ач холбогдлыг оюутнаар гаргуулах аргачлал	5	
		Тулгуур ухагдахууны тодорхойлолтыг хамтран гаргах чадвар	4	
		Харьцуулан жиших, ялгаатай болон төсөөтэй шинжүүдийг тодорхойлох чадвар	4	
		Багшаас судалж буй юмс үзэгдэлд дүн шинжилгээ хийх арга ажиллагаа	4	
Оноо			25	
Дөрөв. Оюутан, сонсогчидтой хичээлийн бус цагаар ажилласан талаар:				
1.	Оюутны бие даалт, судалгааны болон дадлагын ажил удирдсан байдал түүний үр дүн		5	
2.	Багшаас оюутан, сонсогчдын бие даан судлах бүтээл, ашиглах материал, түүнийг гүйцэтгэх даалгаварын аргачлалыг оновчтой гарган өгч, үнэлдэг байдал		5	
3.	Заадаг хичээлтэйгээ холбогдуулан секц, дугуйлан, сонирхогчдын клуб хичээллүүлсэн байдал		5	
Оноо			15	
Тав. Багшийн сурган хүмүүжүүлэх техник ур чадварын талаар:				
1.	Дуу хоолойн өнгө, техник, суралцагчдын анхаарал төвлөрөл		3	
2.	Харц, нүүрний хувирал, суралцагч нэг бүрийг хянах чадвар		3	
3.	Ярианы болон илтгэх урлаг эзэмшилт байдал, техник		4	
Оноо			10	
Зургаа. Үнэлгээний бодит байдлын талаар:				
1.	Багшаас суралцагсдад өгсөн стандарт, стандарт бус үнэлгээ нь хэр бодитой, шинжлэх ухааны үндэстэй байгаа эсэх /сорилоор/		4	
2.	Тухайн хичээлд оролцсон суралцагсдын багшид өгсөн үнэлгээ		4	

	/Оюутнуудаас санал асуулга авч, багшийг үнэлнэ/		
	Суралцагсдаас тухайн хичээлийн чанар, үр дүн, ач холбогдолд өгсөн үнэлгээ /санал асуулгаар/	4	
3.	Багшийн өөрийн заах арга зүй, хичээлийн чанар байдалд өгөх үнэлгээ	3	
Оноо		15	
Нийт оноо		100	

Тайлбар: Багшийг үнэлэхдээ дээрх үзүүлэлт нэг бүрийг 100% гэж тооцон, гүйцэтгэлийг 1-5 оноогоор дүйцүүлэн дүгнэнэ.

СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА